



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/694.

Ховд

Боловсролын байгууллагуудын  
үйл ажиллагааг түр зогсоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "в" заалт, 30 дугаар зүйлийн 30.1.16 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг үндэслэн Улсын Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 12, аймгийн Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 27 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хотод Коронавируст халдвар (КОВИД-19) цар тахлын сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан аймгийн хэмжээнд бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвүүд, үзвэр үйлчилгээний байгууллага, олон нийтийг хамарсан хурал цуглаан, сургалт, соёл урлаг, спортын тэмцээн уралдаан, тоглоомын газруудын үйл ажиллагааг 11 дүгээр сарын 12-ны өдрийн 06:00 цагаас 11 дүгээр сарын 17-ны өдрийн 08:00 цаг хүртэл түр зогсоосугай.

2. Дээрх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл урлагийн газар /М.Пүрэвхүү/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Ч.Уранчимэг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

D/Zah-A/694-Bo